

СҮХБААТАР АЙМГИЙН НАРАН СУМЫН 2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

2022 оны 11 сард албан хэрэг хөтлөлтийн явцад зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийг бүрдүүлж, зааврын дагуу хөтөлж, дээд газраас ирж буй албан бичиг эрхийн актыг хүлээн авч, бүртгэн удирдах албан тушаалтанд танилцуулж, холбогдох албан тушаалтанд шийдвэрлүүлэхээр шилжүүлж, шийдвэрлэлтийн хугацаа, биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа.

-11-р сарын байдлаар дээд газраас 23 нийт албан бичиг ирснээс, хариутай бичиг 7 ирж, 4 албан бичгийн хариуг хугацаанд нь барагдуулж, хугацаа болоогүй 3 албан бичиг байна.

-Мөн нийт 2 эрх зүйн баримт бичиг ирснээс Аймгийн Засаг даргын Захирамж 1, Аймгийн Засаг даргын албан даалгавар 1, ирж хэрэгжиж байна.

-Хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж хугацаатай бичгийн шийдвэрлэлтийн мэдээ, тайланг гаргаж дотоод чатад тавьж мэдээлж ажиллаж байна.

Дотоодын ажлын талаар:

2022 оны 10-р сарын байдлаар;

- 1.Сумын Засаг даргын А-Захирамж – 9
- 2.Сумын Засаг даргын Б-Захирамж - 4
- 4.Засаг даргын албан бичиг -12
- 5.ЗДТГ-ын даргын А-Тушаал -
- 6.ЗДТГ-ын даргын Б-Тушаал - 3
- 7.ЗДТГ-ын даргын албан бичиг - 12

Өргөдөл гомдлын талаар:

2022 оны 11-р сарын байдлаар иргэдээс Засаг дарга болон Тамгын газрын дарга, холбогдох албан тушаалтнуудад хандаж 3 өргөдөл гомдол ирснээс шийдвэрлэгдсэн 0, хугацаа болоогүй 3, шийдвэрлэлтийн хувь 0%.

Архивын ажлын талаар:

☐ Архивын данс бүртгэлийг шинэчлэн, Төрийн архивт 2011-2016 оны баримтыг цахим болон цаасан хэлбэрээр тушаахаар тоо бүртгэлийн ажил хийгдэж эхлээд байна.

☐ 11 сарын байдлаар архиваас 1 иргэн, албан тушаалтанд нийт 4 хадгаламжийн нэгжийг ашиглуулж, лавлагаа хуулбарыг олгосон байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Үндсэн үзүүлэлтүүд:

- Нийт үзлэг-177
- Урьдчилан сэргийлэх-112
- Артерийн гипертензин эрт илрүүлэг-18
- Чихрийн шижин эрт илрүүлэг-18
- Жирэмсний хяналтанд хамрагдсан-3
- Жинэлсэн хүүхдийн тоо-19
- Эмнэлэгт хэвтсэн-63
- Холын дуудлага-13
- Төвийн дуудлага-59

Сургалт сурталчилгаа

“Бэрх биш ээлтэй” хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулганд “Эмийн зохистой хэрэглээ” талаар сургалт орж 3 төрлийн 60ш зөвлөмж тараан ажилласан.



Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлж 45 төрийн албан хаагчдад нэмэлт 3-р тунгын дархлаажуулалтын талаар мэдээ мэдээлэл хийж 3-р тундаа хамрагдах уриалгыг гаргасан.



2021,10,27-28 өдрүүдэд АЭМГ-с “Ковид-19 халдвараас сэргийлэх хариу арга хэмжээ авах, чадавхижуулах” сургалтанд НЭМА, Бага эмч 2 хамрагдсан.

2021.11.12-13ны өдрүүдэд ХӨСҮТ-с ковид-19 халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээний багийг чадавхижуулах суралтанд их эмч нэма нар хамрагдсан.



Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлж


2021.09.04 ковид-19н халдвар дахин бүртгэгдэж нийт тохиолдол 2021.11.20-ны байдлаар 419 тохиолдол бүртгэгдсэн байна.

11-р сард

- Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн-17
- Гэрийн эмчилгээ-67 иргэн хамрагдаж эмчлүүлсэн байна.

Эдгэрсэн-296 хүн байна.

- Гэрийн эмчилгээний иргэдийн эмийг эмийн сангаас авч багцлан иргэдэд хүргэн өгч өдөр бүр утсаар холбогдон биеийн байдлыг асууж хяналт хийж АОК,МХГ,ЭМГ-т илтгэх хуудсаар хүргүүлж байна.



- 10-15 хүний эмчилгээг сувилагч нар хийж эм тариаг авч цаг хугацаанд нь өгч ажилласан..



- Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын судалгааг гаргаж иргэдтэй холбогдож заавар зөвлөж өгч, ойрын хавьтлыг програмд шивэн оруулж байна.
- Ойрын хавьтлын иргэдийг өдөр бүр шинж тэмдгийн болон хяналтын мэдээг авч бидэнд хүргүүлж түүнийг нэгтгэн АОК,МХГ,АЭМГ-т илтгэх хуудсаар хүргүүлж байна.
- Өдөр бүр нөхцөл байдлын мэдээг иргэдэд цахимаар хүргэж байна.
- Ковид-19 халдвараас сэргийлэх 15 төрлийн зөвлөмж болон анхааруулгыг цахимаар иргэдэд хүргэн ажиллаж байна.
- Халдвартай хог хаягдлыг дор бүрэн ангилан ялгаж шатааж байна.
- Ковид-19 халдвараас сэргийлж 3-р тунгын нэмэлт дархлаажуулалтанд иргэдийг хамруулах үйл ажиллагааг зохион байгуулж 928/423/36,9%-тай байна.

Шинэлэг ажил

- Байгууллагынхаа гадна талд ажилчдын ОО хийж байршуулсан. Нүх ухаж, ОО хийх материалаа ажилчид өөрсдөө мөнгө гаргаж материалаа авсан.



- ЗДТГ болон Соёлын төвөөс зохион байгуулсан “ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ГАЗРЫГ ХАМГААЛАХ, ТОХИЖУУЛАХ” уралдаанд Манай хамт олон “ХОНХОР ШҮҮТИЙН 1,2-Р ХҮН ЧУЛУУ”-ны хашаа болон хаягийг хийж байршуулсан.



ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн засаг даргын 2021 оны 03 сарын 19-ны өдрийн А/165 тоот, сумын засаг даргын 2022 оны 04-р сарын 04-ны өдрийн А/25 тоот захирамжын дагуу сумын үржлийн малын 1% -д ангилалтын ажлыг хийж гүйцэтгэх ажлын хүрээнд эм хонь -364, эм ямаа-175, үнээ-55, хуц-497, ухна 254 нийт 1006 толгой малд ангилалт хийж гүйцэтгэхээс эм хонь-435 , эм ямаа-232, үнээ-35 ангилан бүртгэлжүүлж анги чанарт тэнцсэн-186 хуц, 118-ухныг ээмэгжүүлэн бүртгэлжүүлсэн.



2022-2023 оны Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах ,Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 07 сарын 20-ны өдрийн 06 дугаар албан даалгаврыг гарган хэрэгжилтийг хангуулан ажилласан. Аймгийн Засаг даргын 06 дугаар албан даалгаврын дагуу сумдын аюулгүйн нөөцөд өвс тэжээл бэлтгэн нийлүүлэх чиглэлийн дагуу Дарьганга сумын 1-р багийн иргэн Б.Батхүрэлтэй, Сумын засаг дарга болон ХААТ гэрээ байгуулан сумын өвсний фондод 4000 буюу 80 тн боодол өвс татан авахаас одоогийн байдлаар 1600 буюу 40 тн өвсийг бэлтгэн нийлүүлээд байна бэлтгэн нийлүүлээд байна. Малчдын гар дээр 500 тн өвс 30 тн гар тэжээл бэлтгэгдээд байна. Цаашид Дорнод болон Улаанбаатар хотоос тэжээлийн аюулгүйн нөөц бэлтгэн нийлүүлэх ажил зохион байгуулна.





ТАТВАРЫН ЧИГЛЭЛЭЭР:

Татварын ерөнхий газраас зохион байгуулсан цахим сургалтанд хамрагдсан. Татвар төлөгчид татварын холбогдолтой цахим сургалт болон зөвөлгөөг сумын групп шэйр хийж 47 хүн мэдээлэл авсан. Мөн өөрийн хариуцсан ААН-ээр явж онцгой албан татварын лац болон төлбөрийн баримт олголтын талаар хяналт тавьсан.

Татварын орлогын холбоотойгоор 10сарын 20ноос 11сарын 20нд орсон орлого

1. Газрын төлбөрт-26684төгрөг нийт 282220орлого орж татвар хураалт 56,4%-тай байна
2. Малын тоо толгойн албан татварт -5812200төгрөг нийт 30245300төгрөгний татвар хурааж татвар хураалт 38,3%-тай явагдаж байна.
3. Ан амьтны нөөц ашигласаны төлбөр-32400,000
4. Цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан албан татвар-64656206,93
5. Галт зэвсгийн албан татварт-420,000
6. Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар-2512254,56 зэрэг орлого төвлөрөөд байна.

2022оны 10сарын 31 байдлаар сумын нийт орлого-204458732,86 төгрөг буюу 136,6%-тай буюу орлогыг сумын холбогдох дансуудад төвлөрүүлээд байна.

2022оны 11сарын 19, 20ны өдрүүдэд хилийн 0184дүгээр ангийн 5,6 дугаар ангиуд малчдадтай өвөлжилтийн гэрээ байгуулах арга хэмжээнд оролцож 83 малчинд 2021 оны малын тоо толгойн албан татварын мэдээлэл өгч 2022 оны малын тоо толгойн албан татварт төлөлтийн талаар мэдээлэл өгсөн.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР:

3-р багийн засаг даргатай хамтран сумын төвийн золбин нохой устгалын ажлыг зохион байгууллаа. Сумын хэмжээнд нийт 80 нохой устгасан бөгөөд засаг даргын нөөц хөрөнгөөс 800.000 \ найман зуун мянган төгрөг \-н зардал гаргасан.



Онгон сумын хилийн 0184 анги, Сумын засаг дарга, 1, 2-р багийн засаг дарга, Татварын улсын байцаагч нарын хамтаар хил орчмоор нутаглах айл өрхтэй гурвалсан гэрээг байгуулж ажиллаа. Уг ажлын хүрээнд нийт 83 иргэнд хууль бус ан агнуур, гүн өрмийн худаг гаргахад бүрдүүлэх бичиг баримт, зөрчлийн тухай хуулийн талаарх мэдээллийг өгч ажиллаа.



НИЙТИЙН БИЕЙН ТАМИРЫН ЧИГЛЭЛЭЭР:

10 сарын 25 наас эхлэн ахмадууд “ӨГЛӨӨНИЙ АЛХАЛТ “ аяныг эхлүүлсэн.



10 сарын 25 наас эхлэн ЕБС-ийн U9,U10,U11 насны хүүхдүүдэд хөл бөмбөгийн бэлтгэл хийж эхлэсэн.



11 сарын 1-нд ЭМТ- д явуулын амбулатори ирсэн. Үүний зэрэгцээ ард иргэдээс “Идэвхитэй хөдөлгөөн, Эрүүл бие” сэдвээр судалгаа авсан.



11 сарын 2-нд ЭМТ-д ирсэн эмч нарт зориулан “Идэвхитэй хөдөлгөөн, Эрүүл мэнд” уриан дор 19:00 цагаас хөтөлбөрт үдшийн цэнгүүнийг ЭМТ-ийн нийгмийн ажилтан С.Зулцэцэг болон Сумын Залуучуудын холбооны дарга Цолмон нартай хамтран зохион байгуулсан.



БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

[Сургалт хүмүүжлийн талаар](#)

-Хувилбарт сургалтын хүүхдүүдэд зориулан насны ангиллаар “Миний хичээл”, “Би өөрөө”, “Би чадна” гарын авлага бэлтгэсэн. Нийт 55ш жишиг даалгаврыг боловсруулсан.

-“Хүүхэд төвт сургалтын аргазүй” сургалтыг багш, туслах багш нарт явуулж, хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх арга аргачлалыг цаашил хэрэгжүүлэн ажиллахыг чиглэл болгон өгсөн.

-Цэцэрлэгийн удирдлага багш нар Aplus.mn сайтат бүртгүүлж 8 түвшний сургалтад хамрагдаж мэргэжил арга зүйгээ дээшлүүлэн ажиллаж байна. Мөн glassroom программаар онлайн бүлэг нээж багш хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, багшийн хөгжлийн асуудлыг дэмжих, чиглүүлэх ажлыг хийж гүйцэтгэж байна.. Багш нар энэхүү сургалтанд хамрагдсанаар багшийн хөгжлийн хөтөлбөрөө шинэчлэн сайжруулж, цахим орчинд ажиллах ур чадвараа дээшлүүлж байна

Хүүхэд хамгаалал

-Ахлах бүлгийн 1 суралцагчдад кейс нээж, тэтгэмжийн мөнгийг өгөх талаар холбогдох хүмүүстэй уулзан баримт бичгийг бүрдүүлэн аймгийн ГБХЗГ-т хүргүүлсэн.

- Аймгийн ХГБЗХГ-аас ажлын хэсэг ирж, 2022 оны 3-р сарын байдлаар гаргасан эрсдлийн үнэлгээний дагуу өндөр эрсдэлтэй 4 хүүхдэд “Хүүхэд хамгааллын явууллын багц”-ыг өгсөн.



Мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн байдал

-Албан хаагчдын гэр бүлийн дунд “Сайхан бичигтэн” шалгаруулах уралдааныг зарлахад гэр бүл болон хүүхдүүдийн 28 бүтээл ирж, насанд хүрэгчдээс багш Ч.Батцэцэг, хүүхдийн төрлөөс Г.Мөнхзул тэргүүлсэн.

- Судар-Эгшиглэн 2022 төслийн хүрээнд багш ажилчид сар бүрийн 15 ны өдөр НОМЫН НӨХӨР арга хэмжээг зохион байгуулж 9 сарын хугацаанд 15 албан хаагчид 300ш номыг уншиж бусдад түгээн дэлгэрүүлэлт хийсэн. Мөн бие биедээ ном бэлэглэх арга хэмжээг зохион байгуулж, байгууллага дотроо 3 шалгуураар дүгнэж, хамт олны

саналаар байр эзлүүлсэн. нийт 15 хүний номын тэмдэглэлийг Соёлын төвд хүлээлгэн өгсөн.



- Байгууллагын багш ажилчдын дунд “Ёс зүйтэй ажилтан” эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулж нийт 16 багш ажилтан оролцож , шилдгийг тодруулсан.

- Байгууллагын ёс зүйн багтай хамтран “Багш ажилтны ёс зүй” сэдэвт сургалтыг 2 удаа ажлын байран дээр зохион байгуулж ажилласан. Нийт давхардсан тоогоор 26 хүн хамрагдсан.

Хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр

-4-5 настай хүүхдийг номтой нөхөрлүүлэх, ном унших сайхныг мэдрүүлэх үүднээс “Хүүхэд ба ном” сэдэвт аяныг мөн зохион байгуулсан. Аяныг зорилго эцэг эх хүүхэддээ цаг гаргаж үлгэр уншиж өгөх, сонссон үлгэрээ хүүхэд зургаар илэрхийлж бусдад ярьж өгч үгийн баялагийг нэмэгдүүлэхэд оршино. Энэхүү үйл ажиллагааг сар бүр нэгтгэн дүгнэж давхардсан тоогоор 59 хүүхэд оролцсон байна.

-3-5 настай хүүхдүүдийн дунд “Уран илтгэгч” үйл ажиллагааг сар бүр явуулахад нийт 3 бүлгийн 88 хүүхэд хамрагдаж, өөрийгөө илэрхийлэх чадвараа нэмэгдүүлэн бие биенээсээ суралцаж чадсан.



-Бүлгийн хүүхдүүдийн дунд “Бяцхан уншигч” шүлгийн тэмцээнийг явуулахад 4 бүлгийн 84 хүүхэд оролцож, өөрийн уран тод унших чадвараараа өрсөлдсөн.

- “Өглөөний дасгал-Уран хөдөлгөөнт гимнастик” үзүүлэх ажлыг зохион байгуулахад 4 бүлгийн 107 хүүхэд хамрагдсан. Багш нар, ажилчдын ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хийж, эцэг эхчүүдийг идэвхтэй хөдөлгөөн хийхийг уриалсан.

-“Монгол бахархлын өдөр”-ийг угтан хүүхдүүдийн дунд “Тэмүүжний бага нас” хүүхэлдэйг үзүүлж, Чингис хааны тухай мэдээлэл өгсөн. Мөн Чингис хааны тухай болон танин мэдэхүйн асуултаар АХА тэмцээнийг бэлтгэл бүлгийн 31 хүүхдийн дунд зохион явуулсан.



“Тэмүүжин” шүлэг болон дууг сурч, видео бичлэг хийж, байгууллагын цахим хуудсанд байршуулсан. “Ерөөлч, магтаалч хүүхдүүд” өдөрлөгт 4 бүлгийн 111 хүүхэд оролцсон бөгөөд монгол дээлний онцлог, шагай наадгай, ерөөл магтаал унших, төрийн дуулал эгшиглүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.



-Бэлтгэл бүлгийн хүүхдүүдийн дунд “Тэмүүжний бага нас” сэдвээр гар зургийн уралдаан явуулахад 29 бүтээл ирж, үзэсгэлэн гаргасан.

-11сарын 11-ний өдөр буюу “Үлгэрч аав ээж”-ийн өдрийг тохиолдуулан сумын Насан туршийн боловсролын төвийн багштай хамтра “Хүүхэд нэг эрдэнэ-Хүмүүжил мянган эрдэнэ” уриан дор “Ирээдүйнх нь төлөө 15 минут” хамтдаа ном унших аяныг өрнүүлэхэд 4 бүлгийн 89 хүүхэд гэртээ үлгэр уншиж буй бичлэгээ ангийн болон

байгууллагын групп хаягт байршуулсан. Түүнчлэн уншсан үлгэрээрээ ном хийх ажлын хүрээнд 76 бүтээл ирсэн бөгөөд бэлтгэл бүлгийнхэн анги хамт олноороо тэргүүлсэн. Мөн тус өдрөөр 4 эцэг эх ирж үлгэр уншиж өгч, хүүхдүүдтэй нэг өдрийг хамтдаа өнгөрүүлсэн. Бага дунд бүлгийн хүүхдүүдийн дунд уншиж өгсөн үлгэрээр дүрийн тоглолтыг явуулахад 25 хүүхэд жүжигчлэн тоглосон.



-Хүүхдийн уран сайхан унших чадварыг хөгжүүлэх зорилгоор анги болон гэртээ цээжилсэн шүлгээр “Бяцхан уншигч” шүлгийн тэмцээнийг шалгаруулахад 4 бүлгийн 87 хүүхэд оролцож шилдгүүдээ тодруулсан.



Эрүүл ахуй, хоол хүнс

- ХАБЭА ажлын хүрээнд гал тогооны тогооч, туслах ажилтанд заавар зөвөлгөө өгч аюулгүй ажиллагааны зааварчилгаанд гарын үсэг зуруулсан.

-Өдөр бүр хоол хүнсний түүхий эд материалыг тогоочдоо технологийн карт, өдөрлөгийг үндэслэн хяналт тавьж олгож байна.

-Цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэх түүхий эд материалыг гэрээт аж ахуйн нэгжээсээ 7 хоногоор нь хоолны цэс, технологийн картын дагуу худалдан авалт хийж хэвшээд байна.

-Гэрээт аж ахуйн нэгж байгууллагаасаа хүнсний шинжилгээний бичгүүдээ хүлээн авч бүртгэлжүүлсэн.

-Хүүхдийн хоол хүнс хадгалах склад агуулахыг цэвэрлэн хөргөгч хөлдөөгч хүнсний тавиурыг содын уусмалтай усаар цэвэрлэн ариутгал халдваргүйтгэлийг хийсэн.

-Хүүхдийн хоол хүнсэнд нийлүүлж буй түүхий эд бүтээгдэхүүнийг гэрээт ААН байгууллагаас татан авалт хийхдээ хугацааг харж хугацаа хэтэрсэн бүтээгдэхүүнийг буцаан олголт хийж хүүхдийн хоол хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

**ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН**

М.БЯМБАСҮРЭН

**ТАЙЛАНГ ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА**

Э.ЗУЛЦЭЦЭГ